



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/НЧН

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "а", 30 дугаар зүйлийн 30.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит 11 дүгээр хуралдааны 05 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх 7380000 төгрөгийг аймгийн Засаг даргын Ерөнхий дансны Хүүхэд залуучуудад эх оронч үзэл үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг Монгол цэргийн нэгдсэн холбооны Хөвсгөл аймаг дахь салбар холбоонд шилжүүлж зарцуулахыг Төсвийн Ерөнхийлан захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2020 оны 09  
дүгээр сарын 11-ний өдрийн А/Н/Н/Н/  
дугаар захирамжийн хавсралт

ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДАД ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ ХҮМҮҮЖИЛ  
ТӨЛӨВШҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

№	Зарцуулагдах төсвийн задаргаа	Төсөв
1	Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагын дарга нар, төрийн албан хаагчдын дунд зохион байгуулах “Цэргийн буухиа” тэмцээнд	1500000
2	Эх орончдын өдрийн арга хэмжээнд	1000000
3	“Эх орноо магтан дуулья” арга хэмжээнд	600000
4	Тусгаар тогтнол, Монгол бахархлын өдөрт	1600000
5	“Эх орон, эх оронч үзэл хүмүүжил, тусгаар тогтнол үндэсний бахархал”, Миний мэргэжил эх орноо хамгаалагч” сэдэвт шилдэг лекц шалгаруулах	600000
6	Салбар холбоог сурталчлах өдөрлөг арга хэмжээнд	1500000
7	Ахмадын өдөрт зориулж	580000
	Бүгд	<b>7380000</b>